ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон. 206, 207, 210, 213 тоот
7-р баг. Сайнцагаан сум, Дундговь аймаг 48090
Утас: 70592439, 70592208, 70593208
И-мэйл: dundgovi@audit.gov.mn

2024-02-06 № 02/54

танай ________ -ны № ________ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН
ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.АДЪЯАСҮРЭН ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитын явцад тогтоосон төлбөрийн акт, зөрчил арилгах албан шаардлагыг хүргүүлж байна. Төлбөрийн акт, албан шаардлагыг заасан хугацаанд хэрэгжүүлэн хариу ирүүлэхийг хүсье.

Хавсралт ..... хуудас

ДАРГА Р.МӨНХТОГТОХ

0022462064

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# АКТ

2024 оны 02 сарын 06 өдөр Дугаар 18/А/1270470 Мандалговь

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитаар албан томилолтоор ажилласан 8 албан хаагчид 465,000.00 /Дөрвөн зуун жаран таван мянган/ төгрөгийн хоолны мөнгийг давхардуулан олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т /*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*/, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.4-т /*Төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардлын тодорхой хэсгийг байгууллагаас нөхөн олгоно*/, Монгол улсын Сангийн сайдын 2020 оны “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай” 120 дугаар тушаалын 1-т /*Төрийн албан хаагчийн албан томилолтын хоолны зардлыг суманд 24,000 төгрөг, байрны зардлыг 40,000 төгрөг тус тус шинэчлэн батласугай*/ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т /*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-д/*Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон*/ заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Албан хаагчдад илүү олгосон 465,000.00 /Дөрвөн зуун жаран таван мянган/ төгрөгийг Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 100080000955 дугаар дансанд төвлөрүүлэх;

Актын биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэхийг Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Адъясүрэн, нягтлан бодогч Э.Саранзаяа нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТОР Л.УРАНБИЛЭГ

**БАТАЛГААЖУУЛСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

[1] Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113

0012050549

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
# АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 06 өдөр Дугаар 66/А/1270470 Мандалговь

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитаар цалин хөлсний зардлаас **1,359,625.0** /Нэг сая гурван зуун тавин есөн мянга зургаан зуун хорин таван / төгрөгийн шагнал урамшуулал олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т /*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*/, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Эдийн засгийн ангилал ашиглах заавар"-т /*Ажиллагсдын цалин, хөлс болон хуулиар нийгмийн даатгалын шимтгэл бодогдох нэмэгдэл урамшлын зардлууд энэ ангилалд хамаарна. Эдгээр зардлуудыг бүлгийн дүнгээр хянаж болно*/ заасныг тус тус зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т /*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж, холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, зааврыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;
2. Зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 5 дугаар 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэхийг Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын төсвийн шууд захирагч Б.Адъяасүрэн, нягтлан бодогч Э.Саранзаяа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТОР Л.УРАНБИЛЭГ

**БАТАЛГААЖУУЛСАН:**

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

[1] Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113

**ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ**
**Байгууллагын нэр: Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газар**
**Тайлант хугацаа: 2024.01.10**

| № | Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар | Гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын холбогдох хүний | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Албан тушаал | Овог нэр |
| А | 1 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой | Албан томилолтоор ажилласан 8 албан хаагчид хоолны мөнгийг давхардуулан олгосон. | 465,000.00 | Төлбөрийн акт тогтоох | Хүлээн зөвшөөрсөн | Төлбөрийн актыг 2024.05.25-ны өдрийн дотор 100080000955 тоот дансанд төвлөрүүлэх | Төлбөрийн акт тогтоох | Дарга, Нягтлан бодогч | Б.Адъясүрэн, Э.Саранзаяа |
| 2 | Цалин хөлс | Шагнал урамшууллыг цалин хөлсний зардлаас тооцож олгосон | 1,359,625.00 | Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/, 16.5.2-т /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах зарцуулалтад нь хяналт тавих/. | УСНББОУС 1 | Албан шаардлага өгөх | Албан шаардлага өгөх | Дарга, Нягтлан бодогч | Б.Адъясүрэн, Э.Саранзаяа |
| | Нийт дүн | | 1,824,625.00 | | | | | | |

Бэлтгэсэн: Аудитор Л.Уранбилэг

Хянасан: Аудитын менежер Х.Наранцацрал

Хоёр дахь шатанд хянасан: Тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох

Төсөв захирагч: Б.Адъясүрэн

Нягтлан бодогч: Э.Саранзаяа

0823050008 3431274 НД1610